



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/448

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Адаацаг сумын Нийтийн ахуй үйлчилгээний барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Батцэнд Н.Эрдэнэбат	("Оргил төсөл" ХХК-ний захирал) (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Э.Түвшинтөгс Ж.Батхөлөг	("Алтан бат өрлөг" ХХК-ний захирал) (Адаацаг сумын Засаг дарга)
	П.Алтанчимэг	(Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга)

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

433010415